

“Ирээдүйн эрчим хүч”



АРЕВА МОНГОЛ / КОЖЕГОВЬ

• 2015 ОНЫ ЗУНЫ ДУГААР • 05



ӨНЦӨГ

КОЖЕГОВЬ компанид ураны ашиглалтын тусгай зөвшөөрөл олголоо

МЭДЛЭГ, МЭДЭЭЛЛЭЭ ХУВААЛЦЬЯ

- Цөмийн энергийн комисс, Олон улсын атомын энергийн агентлагийн мэргэжилтнүүдийн айлчлал
- 2015 оны эхний Олон нийтийн оролцоотой байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
- Монгол Улсын төлөөлөгчид Казахстан Улсад айлчиллаа
- Сургуулийн сурагчдын дунд байгаль хамгааллыг сурталчлах санаачлага



Тэргүүн өгүүлэл

АРЕВА Монгол ХХК, Кожеговь ХХК-ийн Ерөнхий захирал Тьерри Плэзант

Та бүхэн сайхан наадацгаасан уу?

Баяр Наадмын дараа төслийнхөө талаар сайхан мэдээтэй та бүхэнтэй уулзаж байгаадаа миний бие маш их баяртай байна.

Монгол Улсын Ашигт малтмалын газар, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон орон нутгаас холбогдох зөвшөөрлийг авснаар АРЕВА Монгол компани 2015 оны 6 дугаар сард Дорноговь аймагт хайгуулын кампанит ажлаа эхлүүлсэн билээ. Монгол Улсын эрх бүхий байгууллага, орон нутгийн иргэдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж геологийн хамт олон маань хайгуулын ажлаа үргэлжлүүлэн явуулахад бүх хүчин чармайлтаа дайчлан ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар манай хамт олон хайгуулын ажлаа Монгол Улсын хууль тогтоомж, тухайлбал байгаль хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг нягт баримтлан гүйцэтгэж байна. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа нь АРЕВА Монгол, КОЖЕГОВЬ компанийн хувьд нэн тэргүүний асуудал бөгөөд АРЕВА групп гуравдахь жилдээ зургадугаар сарыг Хөдөлмөрийн Аюулгүй Байдлын сар болгон зарлалаа. АРЕВА Монгол, КОЖЕГОВЬ компаниуд 6 дугаар сарын 26-нд Аюулгүй ажиллагааны өдөрлөгөө “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн соёлыг ажлын байранд нэвтрүүлэе” сэдвээр

зохион байгууллаа. Өдөрлөгт 90 гаруй ажилчид оролцов.

Өнгөрөгч 6 дугаар сард Монгол Улсын Ашигт малтмалын газраас Дорноговь аймаг дахь Дулаан Уул (Дулаан Уул, Өмнөтийн талбайг хамрах) Зөөвч Овоо орд дээр ураны ашиглалтын тусгай зөвшөөрлийг олголоо. Энэ нь Монгол Улсын хувьд түүхэн ач холбогдолтой үе болов. Ийнхүү ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон нь Монгол Улсын Засгийн газар, АРЕВА Монгол компанийн хооронд 2013 оны 10 дугаар сард үзэглэсэн Хувьцаа эзэмшигчдийн гэрээгээр байгуулсан хамтарсан АРЕВА Майнс ХХК-ийн үйл ажиллагааг эхлүүлэх юм.

Бидний ажилд харилцан яриа өрнүүлэх нь маш чухал байдаг. Энэ оны 6 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд Монгол Улсын Төр, Засгийн шийдвэр гаргагчид, холбогдох мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн төлөөлөгчид Казахстан улс дахь Газар доор уусган олборлох аргаар уран олборлодог КАТКО сайтаар зочлов. Монгол, Казахстан Улсууд нь газарзүй, цаг уур мөн геологийн тогтцын хувьд ижил төстэй зүйл олонтой тул энэхүү танилцах айлчлалыг холбогдох байгууллагын мэргэжилтнүүд өндрөөр үнэллээ.

Та бүхэн таалан соёрхож тухлан уншина уу!

ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦОЛ

- АРЕВА Монгол, КОЖЕГОВЬ компани Улаанбадрах сумын 90 жилийн ойн арга хэмжээг дэмжин оролцлоо

ОНЦЛОХ ТООНУУД

- Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт байрлах:
 - Дулаан Уул (Дулаан Уул, Өмнөтийн талбайг хамрах)
 - Зөөвч Овоо ураны 2 ордыг ашиглах тусгай зөвшөөрөл олголоо

Цөмийн энергийн комисс, Олон улсын атомын энергийн Агентлагийн мэргэжилтнүүдийн айлчлал

2015 оны 6 дугаар сарын 18-нд ОУАЭА-ийн хоёр байцаагч, Монгол Улсын ЦЭК-ын ажлын албаны хоёр мэргэжилтний хамт АРЕВА группээс хэрэгжүүлж байгаа төслийн өнөөгийн үйл ажиллагаа болон ирээдүйн төлөвлөгөөтэй танилцах зорилгоор Дулаан Уул, Зөөвч Овоо хээрийн ангиар зочиллоо. Төлөөлөгчид олон сэдвийг сонирхож, ярилцсаны дунд КОЖЕГОВЬ компанийн хайгуулын ажлын түүх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, элсэн чулуун дахь ураны хүдрийн чөмгөн дээж болон цаашид хийгдэх Зөөвч Овоо төслийн үйлдвэрлэлийн туршилтын талаар санал бодлоо солилцов. КОЖЕГОВЬ компанийн 2010 оны 12 дугаар сараас 2011 оны 6 дугаар сарын хооронд хийж гүйцэтгэсэн ГДУО технологийн туршилтын талбай дээр очсон ба зочид цооногийн талбайн хэлбэр, уусгах уусмалын концентраци, шахах болон үйлдвэрлэлийн цооногийн бүтэц, тоноглол мөн цацрагийн хамгаалалт, байгаль хамгааллын талаарх эрхзүйн зохицуулалтын талаар ярилцав. КОЖЕГОВЬ компани хайгуулын үйл ажиллагаандаа ажилчдын цацрагийн шарлагын хяналтыг онцгой анхааран гүйцэтгэдэг билээ. ГДУО технологийн туршилт дээр ажилласан ажилчдын хувийн дозиметрээр хэмжсэн шарлагын хяналтын дүнгээс харахад ажилчдын шарлагын тун нь тухайн нутгийн энгийн ард иргэдийн тунгаас ч бага байв. Монгол Улс ОУАЭА-ийн цөмийн материал, цөмийн аюулгүй ажиллагаанд хамаарах протоколд нэгдэн орох бэлтгэл ажил хийгдэж байгаа үед ОУАЭА, ЦЭК-ын мэргэжилтнүүд АРЕВА Монгол, КОЖЕГОВЬ компанийн үйл ажиллагаатай танилцсан ба хийгдэж буй ажилд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлэв. Монгол Улс 1973 онд ОУАЭА-ийн гишүүн орноор элсэн орсон ба энэ хугацаанд Монгол Улс агентлагтай олон салбарт, тухайлбал цөмийн анагаах ухааны салбарт нягт хамтран ажиллаж ирлээ.



2015 оны эхний Олон нийтийн оролцоотой байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

2015 оны Олон нийтийн оролцоотой байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн эхний кампанит ажлыг 6 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд орон нутгийн 6 иргэний оролцоотой хийж эхлүүллээ. Аргалант, Баян Богд, Зүүнбаян багийн нутаг дээрх зургаан цэгээс усны дээжлэлт хийж, итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээнд явууллаа. Шинжилгээний үр дүн ирэх гуравдугаар улиралд гарна. Мөн цацрагийн тунгийн хэмжилтийг газар дээр нь хийж, АРЕВА Монгол компанийн цацрагийн хамгаалалтын мэргэжилтнүүд ионжуулагч цацраг идэвхт элементийн талаар дэлгэрэнгүй танилцуулгыг нутгийн иргэдэд хийв.

Олон нийтийн оролцоотой байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг компанийн мэргэжлийн багууд, сумдын захиргаа болон иргэд гэсэн 3 талт оролцоонд тулгуурлан 2013, 2014 онуудад амжилттай хэрэгжүүлсэн. Хөтөлбөр хөрс, ус, ургамлын дээжлэлт хийж, хяналт хийх зорилготой билээ. 2015 оны хувьд АРЕВА Монгол компанийн мэргэжилтнүүдээс тодорхой сэдвээр иргэдэд албан бус сургалт зохион байгуулах болон усны хяналт шинжилгээнд түлхүү анхаарч ажиллана. Хөтөлбөр ирэх 8 дугаар сард үргэлжилнэ.

Монгол Улсын төлөөлөгчид Казакстан Улсад айлчиллаа

Монгол Улсын Цөмийн энергийн комиссын ажлын албанаас Төр, Засгийн шийдвэр гаргагчид, холбогдох мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн төлөөлөгчдөд энэ сарын 19-21-ний өдрүүдэд Казакстан Улсад ажлын айлчлал зохион байгууллаа. Айлчлал нь ураны салбар, Газар доор уусган олборлох технологитой илүү дэлгэрэнгүй танилцах зорилготой байлаа.

Казакстан Улс нь уран олборлолтоор дэлхийд тэргүүлдэг бөгөөд 2014 онд нийт олборлолтын 40%-г дангаараа хангасан байна. Айлчлалаар Монголын төлөөлөгчид Казакстан Улсын Төр, Засаг, орон нутгийн удирдлагатай албан ёсны уулзалт хийж, ураны уурхайн эрхзүйн зохицуулалт, хяналтыг хэрхэн хийдэг талаар ярилцаж, КАТКО болон Казатопром компанийн удирдлагатай мөн уулзав. КАТКО компани нь Казакстан Улсын төрийн өмчит, ураны импорт, экспортыг гүйцэтгэгч Казатомпром, АРЕВА группийн хамтарсан компани юм.

Төлөөлөгчид ГДУО аргаар олборлолт явуулдаг дэлхийн хамгийн том уурхайн оператор болох КАТКО компанийн ураны уурхайг үзэж танилцлаа. КАТКО жилд 4000 тонн шар нунтаг үйлдвэрлэдэг юм. Монголын төлөөлөгчид ГДУО цооногийн талбай, боловсруулах үйлдвэрээр зочлохдоо өрөмдлөгийн үйл ажиллагаанаас эцсийн бүтээгдэхүүн болох шар нунтаг савлан гаргах хүртэлх бүх үе шаттай танилцаж чадлаа. Зочид ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, цацрагийн хамгаалалт, байгаль хамгаалал, уурхайн хаалтын дараах нөхөн сэргээлтийг илүү анхаарч, сонирхож байв.

Монгол, Казакстан Улсууд нь газарзүй, цаг уур мөн геологийн тогтоцын хувьд ойролцоо тул энэхүү танилцах айлчлал нь Монгол Улс ураны нөөц баялгаа ашиглах бэлтгэл ажлын хүрээнд холбогдох байгууллагын мэргэжилтнүүдэд өндөр ач холбогдолтой болов.

Сургуулийн сурагчдын дунд байгаль хамгааллыг сурталчлах санаачлага

АРЕВА Монгол компаниас "Бид залуу байгаль хамгаалагчид" хөтөлбөрийг дэмжих ажлын хүрээнд өнгөрөгч 2 дугаар сард байгаль хамгааллыг сурталчилж, хуванцар, цаасан зэрэг өдөр тутмын хог хаягдлын талаар үндсэн ойлголт өгөх зорилгоор Дорноговь аймгийн Улаанбадрах сумын дунд сургуулийн сурагчдын дунд хоёр төрлийн тэмцээн, уралдаан зохион байгууллаа. Уралдаанд дунд сургуулийн 6-18 насны нийт 171 сурагч оролцов.

Компани "Бид залуу байгаль хамгаалагчид" гар зураг, "Эх дэлхий бидний гэр" эссе бичлэгийн уралдааны ялагчдыг 2015 оны 4 дүгээр сард тодруулав. Шагнал гардуулах ажиллагаанд тус сумын ИТХ-ын дарга Ц.Эрхэмболд оролцож: "Байгаль хамгаалал, соёлын өвийг хамгаалах үйлсэд залуу үеийнхний анхаарлыг хандуулах нь хамгийн чухал", хэмээн компанийн санаачлагыг дэмжлээ.

Үүний зэрэгцээ сурагчид компаниас зохион байгуулсан "Хог хаягдалгүй эрүүл орчин" хэлэлцүүлэгт оролцов. АРЕВА Монгол ХХК-ийн Байгаль орчин, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Тогтвортой хөгжил, Орон нутгийн харилцаа хариуцсан захирал Ц.Энхжаргал: "Мэдээллээ хуваалцах, харилцан яриа өрнүүлэх нь бидний үйл ажиллагааны цөм юм. Сурагчдад байгалийн гайхамшигийг танилцуулж, байгаль хамгаалалд тэдний эзлэх байр суурийг тайлбарлан таниулах нь бид бүгдийн хувьд нэн чухал асуудал билээ", гэж цохон тэмдэглэв.

КОЖЕГОВЬ компанид ураны ашиглалтын тусгай зөвшөөрөл олголоо

Монгол Улсын Ашигт малтмалын газраас Дорноговь аймгийн нутаг дахь ураны Дулаан Уул (Дулаан Уул, Өмнөтийн талбайг хамрах), Зөөвч Овоо орд дээр ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2015 оны 6 дугаар сарын 12-ны өдөр КОЖЕГОВЬ компанид олголоо. Энэ нь АРЕВА групп, Мицубиши корпораци (66%) болон Мон-Атом (34%) компанийн хамтарсан компани болох АРЕВА Майнс ХХК үйл ажиллагаагаа бүрэн эхлүүлэхийн өмнөх чухал алхам бөгөөд Монгол Улс энэхүү дэлхийн хэмжээний уул уурхайн төсөлд оролцох боломж бүрдэх юм.

АРЕВА Майнс ХХК нь Зөөвч Овоо орд дээр Газар доор уусган олборлох аргаар үйлдвэрлэлийн хэмжээний туршилт зэрэг техник, эдийн засгийн нарийвчилсан судалгааг хийнэ. ГДУО арга нь газрын гүнээс уран олборлох арга бөгөөд энэ аргаар дэлхий дээрх уран олборлолтын 47%-г гүйцэтгэж байна.

Төслийн техник, эдийн засгийн үзүүлэлтийг баталгаажуулсны дараа АРЕВА Майнс ХХК уран олборлож, экспортлох уурхай байгуулна. Уран олборлох бүхий л хугацаанд Монгол Улсын хууль тогтоомж,

Олон улсын атомын энергийн агентлаг болон АРЕВА группийн өөрийн норм стандартын дагуу АРЕВА Майнс компани байгаль хамгаалах үүргээ биелүүлж, хяналтанд орон нутгийн удирдлага хамтран оролцоно.

1997 оноос эхлэн АРЕВА Монгол компани өөрийн бүрэн эзэмшлийн КОЖЕГОВЬ компаниар дамжуулан ураны геологи хайгуулын ажлыг хийж гүйцэтгэсэн ба тухайн ажлын үр дүнд Дулаан Уул, Зөөвч Овоо ураны ордыг илрүүлсэн. Эдгээр ордын нөөцийг 2011 болон 2013 онуудад тус тус батлуулсан билээ. 2015 оны 2 дугаар сард Монгол Улсын АМГ-ын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл дээрх хоёр ордыг ГДУО аргаар олборлох, хүдэр боловсруулах ТЭЗҮ-г албан ёсоор баталсан юм.

Хариуцлагатай уул уурхайн аж ахуйн нэгжийн хувьд АРЕВА групп сайн дурын үндсэн дээр өргөн хүрээний томоохон нийгмийн хариуцлагын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг ба хөтөлбөр орон нутгийн эдийн засгийн хөгжил, эрүүл мэнд, боловсролыг дэмжсэн орон нутгийн иргэд рүү чиглэсэн төсөл хөтөлбөр байдаг. Мөн харилцан яриа өрнүүлэх, ил тод байдлыг эрхэмлэх нь АРЕВА группийн үйл ажиллагаандаа баримталдаг үндсэн зарчим билээ.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн соёлыг ажлын байранд нэвтрүүлье!



Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа нь АРЕВА группийн хувьд нэн тэргүүний асуудал бөгөөд аюулгүй ажиллагааг ханган ажиллахад компани, гэрээлэгч компанийн ажилчин нэг бүрийн оролцоо, хувь нэмэр шаардлагатай билээ. АРЕВА групп гуравдахь жилдээ зургадугаар сарыг Хөдөлмөрийн Аюулгүй Байдлын сар болгон зарласан ба АРЕВА Монгол, КОЖЕГОВЬ компаниуд 6 дугаар сарын 26-нд Аюулгүй ажиллагааны өдрөө “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн соёлыг ажлын байранд нэвтрүүлье” сэдэвт өдөрлөгөөр зохион байгууллаа. Өдөрлөгт 90 гаруй ажилчид оролцов.

Энэ жилийн өдөрлөгөөр компанийн нийт ажилчид мөн гэрээлэгч компаниудын ажилчдад аюул ослын талаархи ойлголтыг сурталчлан таниулах, аюулгүй ажиллах зан үйлийг хэвшүүлэх, ажлын байран дахь аюул ослыг олж илрүүлэх, тэдгээрийг хэрхэн арилгах арга хэмжээ авах тал дээр ажилтан нэг бүрийн үүрэг оролцоог идэвхижүүлэх олон арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүллээ. “ХАБЭА-н соёлыг ажлын байранд нэвтрүүлье” сэдэвт тэмцээн багуудын дунд явагдсан бөгөөд тэмцээнд КОЖЕГОВЬ компаниас гадна гэрээлэгч Ордгео, Гандриллинг, Урандринлинг, Адэн Сэрвисисийн баг хамт оролцов. Тэмцээний дүнг гаргахад Ордгео, түрүүлж, удаах

байруудад КОЖЕГОВЬ, Гандриллинг компаниуд орлоо. АРЕВА Монгол ХХК-ийн ерөнхий захирал Тьерри Плэзант тус арга хэмжээг нээж үг хэлэхдээ “Бид бүгд нэгдсэн нэг зорилготой ба энэ нь “НЭГ Ч ОСОЛГҮЙ” ажиллах бөгөөд бидний дунд бүрэлдэн тогтсон компанийн аюулгүй ажиллагааны соёлыг улам бэхжүүлэн сайжруулахад анхаарал болгоомжоо сулруулж болохгүй. Бидний өдөр тутмын зөв зан үйл нь бидний өөрийн болон бидний хамтран ажиллагсадын эрүүл мэнд аюулгүй байдлын баталгаа мөн”, гэдгийг цохон тэмдэглэв.



АРЕВА Монгол, КОЖЕГОВЬ компани Улаанбадрах сумын 90 жилийн ойн арга хэмжээг дэмжин оролцлоо

Дорноговь аймгийн Улаанбадрах сум үүсгэн байгуулагдсаны 90 жилийн ойн Баяр Наадам 7 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд ёслол төгөлдөр боллоо. Баярт нийслэл болон бусад аймгуудаас ирсэн 1000 гаруй зочид оролцов. АРЕВА Монгол, КОЖЕГОВЬ компани болон гэрээлэгч компаниуд сумын 90 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж: АРЕВА Монгол- 180 сая төгрөг, Ордгео- 10 000 000 төгрөг, Урандрилинг- 5 000 000 төгрөг, мөн Адэн Сервис 1500 хүний баярын хүндэтгэлийн хүлээн авалтын бэлтгэл ажлыг хангаж, АРЕВА Монгол компани сумын урлаг, спорт, баяр Наадмын цэнгэлдэхийг шинээр барьж идэвхитэй оролцлоо. АРЕВА Монгол компанийн Байгаль орчин, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Тогтвортой хөгжил, Орон нутгийн харилцаа хариуцсан захирал Ц.Энхжаргал: “Өнөөдөр Улаанбадрах сумын хувьд чухал тэмдэглэлт ой болж байна. Бид сумын 90 жилийн ойн Баяр Наадамд оролцож, энэ сайхан мөчийг хуваалцаж байгаадаа



сэтгэл өндөр байна. Манай компанийг “Хамгийн шилдэг хөрөнгө оруулагч”-аар шалгаруулсанд туйлын баяртай байна. Энэ бол АРЕВА Монгол компаниас сум орон нутагт удаан хугацаанд тогтвортой мөн амжилттай ажиллаж ирсний үнэлгээ гэж ойлгож байна. Та бүхэн Сайхан Наадаарай!” хэмээн онцлон тэмдэглэлээ.



1. АРЕВА Монгол компанийн санхүүгийн дэмжлэгтэй шинээр барьсан Улаанбадрах сумын цэнгэлдэхийн нээлт
- 2,3. Ойн Баяр Наадмын парад
- 3,4. АРЕВА Монгол компанийн удирдлага, хамт олон Улаанбадрах сумын удирдлагын хамт
5. Бяцхан бөхчүүд
6. Ойн Баяр Наадмын үеэрх морьтонгуудын үзүүлбэр

БИДЭНТЭЙ ХОЛБОО БАРИХ:

АРЕВА Монгол ХХК

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, ICC-International Commercial Center
3-р давхар

+ (976) 11-320698, 70110675

+ (976) 11-329037

webmaster-mongolia@areva.com

http://mongolia.areva.com